

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/20/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Дарга тэргүүлэх аудитор: Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	17
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.6.3 Нэмэлт төсөв	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР - 425
ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Э. ТАМИР ТАНАА**

2022.08.25 № *16*

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020058

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	217,131,597.84	195,570,408.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,710,873.65	16,197,216.09
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,710,873.65	16,197,216.09
31210	Төгрөг	7,710,873.65	16,197,216.09
31211	Төрийн сангийн харилцах	7,710,873.65	16,197,216.09
33	АВЛАГА	2,948,394.63	3,287,468.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,948,394.63	3,287,468.20
35	БАРАА МАТЕРИАЛ	206,472,329.56	176,085,724.05
35100	Түүхий эд материал	44,821,609.80	44,836,643.20
35110	Тусгай зориулалттай материал	44,057,619.30	44,313,474.30
35130	Эм боох материал	763,990.50	523,168.90
35400	Хангамжийн материал	91,130,719.76	67,069,080.85
35420	Аж ахуйн материал	45,600,078.04	35,666,751.84
35440	Түлш, шатах тослох материал	1,407,755.00	981
35450	Барилгын засварын материал	2,787,801.01	4,787,801.01
35460	Хүнсний материал	41,335,085.71	26,613,547.00
35600	Мал амьтад	70,520,000.00	64,180,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,036,886,247.99	2,916,732,084.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,036,886,247.99	2,916,732,084.94
39200	Биет хөрөнгө	2,830,726,247.99	2,710,572,084.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,905,108,286.30	2,961,802,329.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-371,059,490.11	-514,670,112.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,703,333.00	167,603,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-127,906,879.25	-137,862,268.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	445,251,218.10	500,395,739.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-229,022,895.43	-299,119,370.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,977,989.12	60,876,099.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,996,715.74	-48,125,067.62
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	19,671,402.00	19,773,292.12
39212	Хуримтлагдсан элэгдэл	0	-101,890.12
39300	Биет бус хөрөнгө	206,160,000.00	206,160,000.00
39301	Програм хангамж	7,134,292.31	7,134,292.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,134,292.31	-7,134,292.31
39303	Бусад биет бус хөрөнгө	206,160,000.00	206,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,254,017,845.83	3,112,302,493.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,651,388.58	7,366,424.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,651,388.58	7,366,424.19
41300	Өглөг	10,651,388.58	7,366,424.19
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	106,477.06	65,722.67

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41360	Бусад өглөг	10,544,911.52	7,300,701.52
41361	Байгууллагад төлөх өглөг	9,000,000.00	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,544,911.52	7,300,701.52
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,243,366,457.25	3,104,936,069.09
51	Засгийн газрын хувь оролцоо	3,243,366,457.25	3,104,936,069.09
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	467,792,157.00	467,792,157.00
51200	Хуримтлагдсан үр дүн	374,729,869.85	236,299,481.69
51210	Өмнөх үеийн үр дүн	583,176,071.90	374,729,869.85
51220	Тайлант үеийн үр дүн	-208,446,202.05	-138,430,388.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,400,844,430.40	2,400,844,430.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,254,017,845.83	3,112,302,493.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,653,745,530.47	1,663,577,416.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	183,902,130.47	174,676,626.59
120	Нийтлэг татварын бус орлого	183,902,130.47	174,676,626.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,714,807.84	64,892,986.15
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,856,100.00	50,088,900.15
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,858,707.84	14,804,086.00
120009	Бусад орлого	11,280,962.13	9,011,552.44
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,590,000.00	83,066,873.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	95,316,360.50	17,705,215.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,469,843,400.00	1,488,900,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,469,843,400.00	1,475,156,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,469,843,400.00	1,475,156,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	13,744,590.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	9,244,590.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,862,191,732.52	1,800,940,804.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,862,191,732.52	1,800,940,804.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,820,011,332.52	1,758,158,750.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,033,347,926.66	1,028,584,933.39
210101	Үндсэн цалин	694,437,873.66	697,653,072.70
210102	Нэмэгдэл	338,910,053.00	330,931,860.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,981,270.74	20,402,456.93
210201	Тэтгэврийн даатгал	1,741,803.45	334,011.63
210205	Эрүүл мэндийн даатгал	20,239,467.29	20,068,445.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,649,915.56	159,863,351.53
210301	Гэрэл, цахилгаан	94,460,468.07	89,895,416.81
210302	Түлш, халаалт	66,189,447.49	67,367,934.72
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60,835,796.49	60,540,452.46
210401	Бичиг хэрэг	5,574,400.00	7,064,178.46
210402	Тээвэр, шатахуун	42,707,396.49	31,482,574.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,773,500.00	2,615,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,300.00	32,300.00

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,491,700.00	1,466,200.00
210408	Бараа материал акталсны зардал	8,256,500.00	17,880,000.00
2105	Нормативт зардал	255,738,186.63	207,517,432.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,842,240.00	7,926,521.60
210502	Хоол, хүнс	205,035,028.29	180,662,624.71
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	39,860,918.34	18,928,286.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,315,510.86	20,309,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,414,700.00	314,700.00
210604	Урсгал засвар	8,900,810.86	19,995,100.00
2107	Томилолт, зочны зардал	46,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	46,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,744,300.00	3,627,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,083,000.00	1,083,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,800.00	271,046.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,208,500.00	1,208,500.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	270,352,425.58	256,812,777.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,763,250.00	22,457,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	534,300.00	463,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	257,054,875.58	233,892,727.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,180,400.00	42,782,054.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,111,300.00	11,373,100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,111,300.00	11,373,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,069,100.00	6,392,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,069,100.00	6,392,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	16,754.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	16,754.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,000,000.00	25,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,000,000.00	25,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-208,446,202.05	-137,363,388.16
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	1,067,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	1,067,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-208,446,202.05	-138,430,388.16

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	580,959,153.82	3,449,595,741.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,216,918.08	2,216,918.08
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	583,176,071.90	3,451,812,659.30
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-208,446,202.05	-208,446,202.05
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	374,729,869.85	3,243,366,457.25
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	374,729,869.85	3,243,366,457.25
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	374,729,869.85	3,243,366,457.25
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-138,430,388.16	-138,430,388.16
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	467,792,157.00	2,400,844,430.40	236,299,481.69	3,104,936,069.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,553,663,562.74	1,575,077,534.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,820,162.74	86,176,744.31
120	Нийтлэг татварын бус орлого	83,820,162.74	86,176,744.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	72,679,200.61	77,165,191.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	72,679,200.61	77,165,191.87
120009	Бусад орлого	11,140,962.13	9,011,552.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,469,843,400.00	1,488,900,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,469,843,400.00	1,475,156,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,469,843,400.00	1,475,156,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	13,744,590.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	4,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	9,244,590.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,560,736,230.67	1,535,919,499.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,560,736,230.67	1,535,919,499.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,518,555,830.67	1,493,137,445.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,027,573,300.00	1,021,690,600.00
210101	Үндсэн цалин	687,502,400.00	672,493,400.00
210102	Нэмэгдэл	337,670,900.00	345,021,200.00
210104	Урамшуулал	2,400,000.00	4,176,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,781,200.00	23,991,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,781,200.00	23,991,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,922,539.14	159,863,351.53
210301	Гэрэл, цахилгаан	94,460,468.07	89,895,416.81
210302	Түлш, халаалт	69,462,071.07	67,367,934.72
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,650,400.00	39,595,078.46
210401	Бичиг хэрэг	5,574,400.00	5,405,578.46
210402	Тээвэр, шатахуун	37,778,500.00	30,075,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,773,500.00	2,615,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,300.00	32,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,491,700.00	1,466,200.00
2105	Нормативт зардал	180,017,300.00	168,738,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,677,300.00	6,625,700.00
210502	Хоол, хүнс	171,340,000.00	162,113,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,315,510.86	27,204,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	5,032,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,414,700.00	314,700.00

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	8,900,810.86	21,856,800.00
2107	Томилолт, зочны зардал	46,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	46,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,952,030.67	28,634,466.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,290,730.67	26,089,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,800.00	271,046.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,208,500.00	1,208,500.00
210807	Газрын төлбөр	1,000,000.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,297,550.00	22,920,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,763,250.00	22,457,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	534,300.00	463,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,180,400.00	42,782,054.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,111,300.00	11,373,100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,111,300.00	11,373,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,069,100.00	6,392,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,069,100.00	6,392,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	16,754.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	16,754.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,000,000.00	25,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,000,000.00	25,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-7,072,667.93	39,158,034.32
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,286,000.00	30,671,691.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,286,000.00	30,671,691.88
2200	Дотоод эх үүсвэрээр	6,286,000.00	30,671,691.88
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,286,000.00	30,671,691.88
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,286,000.00	-30,671,691.88
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-13,358,667.93	8,486,342.44
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,069,541.58	7,710,873.65
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,710,873.65	16,197,216.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,510,425,600.00	1,496,786,927.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,510,425,600.00	1,496,786,927.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,492,660,300.00	1,479,021,627.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,021,690,600.00	1,021,690,600.00
210101	Үндсэн цалин	672,493,400.00	672,493,400.00
210102	Нэмэгдэл	345,021,200.00	345,021,200.00
210104	Урамшуулал	4,176,000.00	4,176,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,991,200.00	23,991,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,991,200.00	23,991,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,573,300.00	159,863,351.53
210301	Гэрэл, цахилгаан	78,494,000.00	89,895,416.81
210302	Түлш, халаалт	81,479,300.00	67,367,934.72
210303	Цэвэр, бохир ус	2,600,000.00	2,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,202,700.00	37,550,488.46
210401	Бичиг хэрэг	4,426,700.00	4,360,988.46
210402	Тээвэр, шатахуун	34,662,300.00	29,075,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,615,200.00	2,615,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	32,300.00	32,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,466,200.00	1,466,200.00
2105	Нормативт зардал	168,738,700.00	168,738,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,625,700.00	6,625,700.00
210502	Хоол, хүнс	162,113,000.00	162,113,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,621,900.00	54,875,691.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,664,200.00	35,704,191.88
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,414,700.00	314,700.00
210604	Урсгал засвар	19,543,000.00	18,856,800.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,205,300.00	3,627,546.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,644,000.00	1,083,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,800.00	271,046.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,208,500.00	1,208,500.00
210807	Газрын төлбөр	900,000.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,136,600.00	8,184,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,673,600.00	7,721,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	463,000.00	463,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,765,300.00	17,765,300.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	11,373,100.00	11,373,100.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	11,373,100.00	11,373,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,392,200.00	6,392,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,392,200.00	6,392,200.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,510,425,600.00	1,496,786,927.87
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,475,156,200.00	1,475,139,446.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,475,156,200.00	1,475,139,446.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,269,400.00	21,647,481.87

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,269,400.00	21,647,481.87
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	175.00	161.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	87.00	80.00
620001	Удирдах ажилтан	2.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	63.00	59.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	20.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	87.00	80.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0.00	0.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	86.00	80.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,744,590
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,744,590
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,744,590
2104	Хангамж, бараа материалын зардал	2,044,590
210401	Бичиг хэрэг	1,044,590
210402	Тээвэр, шатахуун	100,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000
210604	Урсгал засвар	3,000,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,700,000
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,700,000
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,744,590
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,744,590
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,244,590
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн тогтвортой байдалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/68 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга-Төсвийн төвлөрүүлэн захирагчтай 2021 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 чиглэлийн хүрээнд 60 заалтаар гарган Төсвийн төвлөрүүлэн захирагч, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын даргаар батлуулан ажилласан бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 97 хувь буюу “маш сайн” үнэлгээ авч дүгнэгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,862,191.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 27,932.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,553.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,619.3 мянган төгрөгөөр буюу 17.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр эздийн өмч дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,710.9	16,197.2	8,486.3
Авлага	2,948.4	3,287.5	339.1
Бараа материал	206,472.3	176,085.7	-30,386.6
Үндсэн хөрөнгө	3,036,886.2	2,916,732.1	-120,154.2
Нийт хөрөнгө	3,254,017.8	3,112,302.5	-141,715.4
Өр төлбөр	10,651.4	7,366.4	-3,285.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,243,366.5	3,104,936.1	-138,430.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,254,017.8	3,112,302.5	-141,715.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 16,197.2 болж 8,486.3 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сангийн дансанд байрших ахмадын сан 8,896.5 мянга, ялтны нэрийн дансны үлдэгдэл 7,300.7 мянга байна.

Авлага дансны үлдэгдэл 3,287.5 мянган төгрөг болж нэмэгдсэн нь нийгмийн даатгалын тайланд албан хаагчдын цалинг илүү тайлагнасан, төрлийг энгийнээр сонгосон зэрэг тооцооллын алдаанаас үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 176,085.7 мянган төгрөг болж 30,386.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүн буурсан, 17,880.0 мянган төгрөгийн малын зүй бус хорогдол гарч данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 3,036,886.2 мянган төгрөг байсан ба 120,154.2 мянган төгрөгөөр буурчээ. Тайлант хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 46 дугаар тогтоолоор орон сууцны барилгын фасад 56,694.0 мянга,

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны А-1/2222 дугаартай албан бичгээр 2,001.9 мянга, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын даргын 2021 оны А/168 дугаар тушаал болон нэгдсэн хангалтаар 26,372.8 мянга, нийт 85,068.7 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого хүлээн авч, 30,671.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвөөс худалдан авч, 233,892.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,366.4 мянган төгрөг болж 3,285.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос байгууллагад төлөх өр 9,000.0 мянга, ялтны нэрийн дансны өр 1,544.9 мянга, нийт 10,544.9 мянган төгрөгөөр буурч, хувь хүний орлогын албан татварын өр 65.7 мянга, ялтны нэрийн дансны өр 7,300.7 мянган төгрөг болж нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,104,936.1 мянган төгрөг болж 138,430.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн байна.

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 9,831.9 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого 13,744.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 61,250.9 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Үүнд: Нормативт зардлууд 48,220.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 13,539.6 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн 2,175,496.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 54,000.0 мянга, нийт 2,227,496.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 2,227,496.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,421,706.42 мянган төгрөгөөр бууруулж, 1,423,933.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд нийт 3 удаа төсөвт өөрчлөлт оруулж, жилийн эцсийн байдлаар 1,510,425.6 мянган төгрөгөөр санхүүжилтийг баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70705 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,510,425.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,475,156.2 төгрөгийг улсын төсвөөс, 35,269.4 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,475,139.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 21,647.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,496,786.9 мянган төгрөг зарцуулж, 16.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
70705-Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,450,749,300.0	1,450,732,546.0	16,754.0
	80102-Туслах үйл ажиллагааны зардал	35,269,400.0	21,647,481.9	13,621,918.1
	80229-Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	5,558,600.0	5,558,600.0	-
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	6,392,200.0	6,392,200.0	-
	80220-Холбооны суваг ашигласны хөлс	1,083,000.0	1,083,000.0	-
	80821-Төрөөс нийгмийн даатгалыг хариуцах	11,373,100.0	11,373,100.0	-
	Нийт дүн		1,510,425,600.0	1,496,786,927.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газраас өршөөлийн хуулийг хэрэгжүүлэхэд 2,044.6 мянга, 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд олгосон 7,200.0 мянган төгрөгийн урамшуулал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 3,000.0 мянга, Байгаль орчин, аялал жуулчлалын газраас “Зөв дадал эерэг өөрчлөлт” арга хэмжээний шагнал 1,500.0 мянга, нийт 13,744.6 мянган төгрөгийг орлого бүртгэж, гүйцэтгэлээр 13,744.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

3.8 Аудитын гол асуудал

Илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь 2021 онд нийт 2,210,382.2 мянган төгрөгийн 74 мэдээллийг байршуулахаас 2,210,382.2 мянган төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тухайлбал: Түлш халаалт, Хоол хүнсний багц 2, 3-т шууд гэрээ байгуулахдаа үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжид үндэслэхгүйгээр гэрээ байгуулсан зөрчил илэрсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 5 сарын 28-ны 13е/77 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын баланст бүртгэлтэй малаас 199 толгой буюу 17,880.0 мянган төгрөгийн мал зүй бусаар хорогдсон нь анхаарал татаж байгаа бөгөөд данснаас хасахдаа үндэслэж буй баримтууд нь анхан шатны баримтын шаардлага хангахгүй байгаа нь анхаарал татаж байна.

Мөн цалин хөлсний бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгээгүй өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд давтагдан гарч байгаа нь дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 115,879.0 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс, 97,958.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 266.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 17,154.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 500.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хагас жилийн санхүүгийн тайланд 6,113.5 мянган төгрөгийн өр төлбөрийг нэмэгдүүлж үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн

- 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул завсрын аудитаар зөрчил арилгах зөвлөмж өгч залруулсан.
2. Завсрын аудитаар санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэж ирүүлээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 3 дугаар зүйлийн 3.1, санхүүгийн тайлангийн толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул зөрчлийг арилгах зөвлөмж өгч залруулсан.
 3. 6-р сарын малын тайланг бэлтгээгүй. Шинэ төл болон нас дэвшилтийн орлого, зарлагыг анхан шатны баримтад үндэслэж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, ШШГЕГ-ын НБББББ-ийн 4.3.2.1 дэх заалтыг зөрчсөн тул аудитын явцад залруулсан.
 4. Нийгмийн даатгалын тайланд 13 албан хаагчийн цалинг 8,237.0 мянган төгрөгөөр илүү, 5 албан хаагчийн 427.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.1, 17.1.1 дэх заалтыг зөрчсөн тул аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Байгууллагын дотоод журмыг үндэслэн 1,102.2 мянган төгрөгийн тэтгэмж олгосон боловч 110.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Хувь хүний орлогыг албан татвараас чөлөөлөх, албан татварын хөнгөлөлт эдлүүлэх журам"-ын 2.2 дах заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

2. ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцсон. 38 ажилтанд олгох 89.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг дутуу, 14 ажилтанд 67.4 мянган төгрөгийн хөнгөлөлтийг илүү олгосон боловч авлага, өр төлбөрөөр тооцоо үүсгэж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Завсрын аудитаар өгсөн авлага бууруулж ажиллах зөвлөмжийг биелүүлээгүй. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цэргийн албан хаагчийг энгийн ажилтнаар тайлагнаснаас шалтгаалж 3,287.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дах заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т заасны дагуу албан шаардлага өгөв.

2. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 13,866.9 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаагүй томилолтын зардлыг 2021 онд тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй аливаа төлбөрийг санхүүжүүлэхгүй байх, зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан 205,580.6 мянган төгрөгийн 73 нэр төрлийн 88 ширхэг үндсэн хөрөнгийг үнэлж бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 5.1.4, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Ашиглах боломжтой хөрөнгийг үнэ тогтоох, ашиглах боломжгүй тохиолдолд акталж устгах

3. Төлбөрийн баримт нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цахим төлбөрийн системд хяналт тавьж ажиллаагүй. 18 байгууллагын 37,640.7 мянган төгрөгийн худалдан авалт мэдээлэгдээгүй, 15 байгууллага 7,417.6 мянган төгрөгийн төлбөрийн баримт илүү бичигдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Цахим төлбөрийн системд хяналт тавьж ажиллах, төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг хийхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги	11	115,879.0	4	97,958.0	2	266.6	2	17,154.4	3	500.0